



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 11 өдөр

Дугаар А/592

Булган сум

Хяналт шалгалтын арга хэмжээг зохион байгуулах тухай

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, 16.2.4, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.6, 17.2.20, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1, 5.5.4, Усны тухай хуулийн 18.1.1, Засгийн газрын 2023 оны “Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай” 79 дүгээр тогтоол, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны “Хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалт батлах тухай” А/117 дугаар тушаал, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны “Булган аймгийн 2023 оны төсөв батлах тухай” XIV/01 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль орчны чиглэлээр 2023 онд төлөвлөгөөт хяналт шалгалт хийх объект, хууль бусаар мод бэлтгэх, амьтныг агнах, барихыг хориглосон хугацаанд хууль бус ан агнууртай тэмцэх хяналт шалгалтыг 2023 оны 08 дугаар сарын 10-ны өдрөөс 09 дүгээр сарын 31-ний өдрийг дуустал маршрутын дагуу зохион байгуулсугай.

2. Хяналт шалгалтыг зохион байгуулах ажлын удирдамжийг нэгдүгээр, шаардагдах зардлын тооцоо, маршрутыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Дээрх арга хэмжээнд шаардагдах зардал 9 294 150 (Есөн сая хоёр зуун ерэн дөрвөн мянга нэг зуун тавь) төгрөгийг Байгаль орчны багц хуулийн хэрэгжилтийг хангах хяналт, шалгалт хийх, тооллого судалгааны ажил явуулах зардлаас гаргахыг Байгаль хамгаалах сангийн нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтийг удирдамж, төлөвлөгөөнд заасны дагуу зохион байгуулж, шаардагдах хүн хүч, техник хэрэгслээр тухай бүрд нь хангаж, хамтран ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (А.Гантөмөр), Цагдаагийн газрын дарга (Цагдаагийн хурандаа Л.Ганбаатар), сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 11-ны/ний өдрийн 11 дүгээр/дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг.Шалгалтын зорилго

Засгийн газрын “Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай” 79 дүгээр тогтоолыг үндэслэн иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд болон хууль бусаар мод, байгалийн ургамал, ойн дагалт баялаг түүж бэлтгэх, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, агнуурын нөөц газруудад амьтныг агнах, барихыг хориглосон хугацаанд хууль бус ан агнууртай тэмцэх хяналт шалгалтыг Байгаль орчныг хамгаалах тухай, Амьтны тухай, Ойн тухай, Байгалийн ургамлын тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Хог хаягдлын тухай хуулиуд болон тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг шалгаж, зөрчил дутагдал гарахаас урьдчилан сэргийлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах цаашид авах арга хэмжээний санааг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлэхэд хяналт шалгалтын зорилго оршино.

Хоёр.Шалгалтын хүрээ, шалгалтад хамрагдах аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, объектын нэр

2.1.Амьтны тухай хуулиар заасан агнуурын амьтныг агнах, барихыг хориглосон хугацаанд хууль бус ан, агнууртай тэмцэх, урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх;

2.2.Ан агнуурын холбоотой үйл ажиллагаанд Амьтны тухай хууль тогтоомжид заасан зөвшөөрөл /эрхийн бичиг, тусгай зөвшөөрөл, гэрээ г.м/ гарал үүслийн тодорхойлолт болон бусад баримт бичигт хяналт шалгалт хийх;

2.3.Амьтны тухай хуулиар заасан хориглосон арга, зэвсэг хэрэгсэл, үйл ажиллагаанд хяналт тавих;

2.4.Аймаг орон нутгийг холбосон төв зам, ойн, амьтны нөөц газрууд, тухайн газраар хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгслүүдэд үзлэг хийх;

2.5.Амьтны тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх заалтын хэрэгжилтэд хяналт тавих;

2.6.Ойн тухай хуулийн 26 дугаар зүйлийн хэрэгжилт, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж байгаа байдалд хяналт тавих;

2.7.Мод, ойн дагалт баялаг, байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх, худалдах, тээвэрлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор тээврийн хэрэгслийн ачаа тээшинд үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

2.8.Тухайн орон нутагт ойн сан бүхий газрыг гэрээгээр эзэмшиж мод бэлтгэлийн үйл ажиллагаа явуулж байгаа ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, ойн мэргэжлийн байгууллагуудад шалгалт хийх;

2.9.Ойн ашиглалтын мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанд 01.2.2 кодтой “Ой ашиглалтын мэргэжлийн байгууллагын мод бэлтгэлийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх байдлыг шалгах хяналтын хуудас”-аар эрсдэлийг үнэлэх, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах;

2.10.Шатахуун түгээх станц, аялал жуулчлалын бааз, амралтын газрын үйл ажиллагаанд 01.1.4 кодтой “Үйлдвэрлэл үйлчилгээ, үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх байдлыг шалгах” хяналтын хуудасны асуумжаар хяналт шалгалт хийнэ.

Гурав. Шалгалтын төрөл

3.1.Төлөвлөгөөт хяналт шалгалт хийх;

Дөрөв. Шалгалтын арга

4.1.Хяналт шалгалтыг батлагдсан удирдамжид тусгагдсан асуудлын хүрээнд хийхээс гадна Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон бусад эрх зүйн баримт бичгийн хүрээнд хийж гүйцэтгэнэ.

4.2.2023 онд Байгаль орчны чиглэлээр төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдэх 30 объектын үйл ажиллагаанд шалгалт хийхээс гадна, хөдөлгөөнт эргүүл хэлбэрээр хяналт тавих, иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудаас ирүүлсэн гомдол мэдээллийн дагуу шалгалт хийх, тээвэрлэгдэж буй ачаа тээшинд үзлэг хийх зэрэг аргуудаар хийж гүйцэтгэх бөгөөд шалгалттай холбоотой баримт бичгийг хянаж үзэх, шаардлагатай тохиолдолд дуу дүрсний бичлэг хийх, фото зураг авах, төрийн байгууллагуудад хадгалагдаж байгаа баримт бичигтэй тулгалт хийх, тэдгээрийг хуулбарлах, лавлагаа мэдээлэл авах зэрэг ажиллагаануудыг хийж гүйцэтгэнэ.

Тав. Шалгалтын бүрэлдэхүүн

5.1.Байгаль орчин, аялал жуулчлалын газар – 2, БОХУБ, мэргэжилтэн – 1;

Цагдаагийн газар – 1;

Сумын байгаль орчны хяналтын Улсын байцаагч, байгаль хамгаалагч – 1;

Зургаа. Шалгалт эхлэх болон дуусах хугацаа

6.1.Шалгалтыг 2023 оны 08 дугаар сарын 10-ны өдрөөс 09 дүгээр сарын 31-ний өдрийг дуустал маршрутын дагуу зохион байгуулна.

Долоо. Шалгалтын дүнг танилцуулах

7.1.Хамтарсан хяналт шалгалтын хүрээнд хийгдсэн шалгалтын танилцуулгыг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны салбарын хяналтын газарт хүргүүлэх;

7.2.Хяналт шалгалтын талаар цаашид авч хэрэгжүүлэх санал боловсруулж, олон нийтэд мэдээлж ажиллана.

Найм. Өмнө хийсэн шалгалтын талаарх мэдээлэл

Хууль бусаар мод, байгалийн ургамал, ойн дагалт баялаг түүж бэлтгэх, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, агнуурын нөөц газруудад амьтныг агнах, барихыг хориглосон хугацаанд хууль бус ан агнууртай тэмцэх урьдчилан сэргийлэх шалгалт 2022 онд аймгийн хэмжээнд зохион байгуулсан.

Аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 11-ны/ний өдрийн 4592 дүгээр/дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

Хяналт шалгалт хийх замын маршрут 8 дугаар сард

№	Хяналт шалгалт явуулах чиглэл	Явах замын хэмжээ /км/	Хугацаа
1	Булган Орхон	25	1
2	Орхон сумын нутгаар	50	
3	Орхон - Хишиг-Өндөр	45	
4	Хишиг-Өндөр сумын нутгаар	70	2
5	Хишиг-Өндөр - Могод	60	
6	Могод сумын нутгаар	200	
7	Могод - Сайхан	130	2
8	Сайхан сумын нутгаар	200	
9	Сайхан - Баян-Агт	70	2
10	Баян-Агт сумын нутгаар	200	
ii	Баян-Агт - Булган	150	
Дүн		1200	7

Төлөвлөгөөт болон хөдөлгөөнт хяналт, шалгалтад зарцуулагдах хөрөнгө

№	Зардал	Зарцуулах	Нэг бүрийн өртөг	Нийт өртөг
1	Шатахуун	1200/100*17=204 л	3 550 төг	724 200
2	Томилолт	5 хүн * 7 хоног =35	64 000төг	2 240 000
Дүн				2 964 200

Хяналт шалгалт хийх замын маршрут 8 дүгээр сард

№	Хяналт шалгалт явуулах чиглэл	Явах замын хэмжээ /км/	Хугацаа
1	Булган Бүрэгхангай	80	1
2	Бүрэгхангай сумын нутгаар	100	
3	Бүрэгхангай - Дашинчилэн	70	1
4	Дашинчилэн сумын нутгаар	50	
5	Дашинчилэн - Гурванбулаг	150	1
6	Гурванбулаг сумын нутгаар	100	
7	Гурванбулаг - Баяннуур	30	1
8	Баяннуур сумын нутгаар	20	
9	Баяннуур - Рашаант	110	2
10	Рашаант сумын нутгаар	100	
11	Рашаант - Булган	220	
Дүн		1030	6

Төлөвлөгөөт болон хөдөлгөөнт хяналт, шалгалтад зарцуулагдах хөрөнгө

№	Зардал	Зарцуулах	Нэг бүрийн өртөг	Нийт өртөг
1	Шатахуун	$1030/100*17=175$ л	3 550 төг	621 250
2	Томилолт	4 хүн * 6 хоног =24	64 000 төг	1 536 000
	Дүн			2 157 250

Хяналт шалгалт хийх замын маршрут 9 дүгээр сард

№	Хяналт шалгалт явуулах чиглэл	Явах замын хэмжээ /км/	Хугацаа
1	Булган - Хутаг-Өндөр	150	2
2	Хутаг-Өндөр сумын нутгаар	200	
3	Хутаг-Өндөр – Тэшиг	103	2
4	Тэшиг сумын нутгаар	200	
5	Тэшиг - Булган	246	
6	Булган - Бугат	52	1
7	Бугат сумын нутгаар	150	
8	Бугат – Сэлэнгэ	90	2
9	Сэлэнгэ сумын нутгаар	150	
10	Сэлэнгэ – Хялганат тосгон	26	2
11	Хялганат тосгоны нутгаар	100	
12	Хялганат - Хангал	30	1
13	Хангал - Булган	113	
	Дүн	1610	10

Төлөвлөгөөт болон хөдөлгөөнт хяналт, шалгалтад зарцуулагдах хөрөнгө

№	Зардал	Зарцуулах	Нэг бүрийн өртөг	Нийт өртөг
1	Шатахуун	$1610/100*17=274$ л	3 550 төг	972 700
2	Томилолт	5 хүн * 10 хоног =50	64 000төг	3 200 000
	Дүн			4 172 700

Нийт зардал

№	Хяналт шалгалт явуулах хугацаа	Нийт өртөг
1	8 дугаар сард	2 964 200
2	9 дүгээр сард	2 157 250
3	9 дүгээр сард	4 172 700
	Нийт дүн	9 294 150